



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/138/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Мандалговь хот 2022 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225 Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Т.Батсайхан Утас: 70593113 Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn</p> <p>Аудитор: Д.Должинсүрэн Утас: 70593113 Цахим хаяг: Doljinsuren@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

.....	0
1.Аудитын санал дүгнэлт	2
.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.2 Төлбөрийн акт.....	16
4.3 Албан шаардлага.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.Аудитын санал дүгнэлт



**АДААЦАГ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
С.ОТГОНБАЯР ТАНАА**

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

0012020819

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>75,104,791.92</u>	<u>330,681,887.64</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	2,522,164.40
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	2,522,164.40
3121	Төгрөг	-	2,522,164.40
31211	Төрийн сангийн харилцах	-	484,843.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	2,037,321.40
33	АВЛАГА	51,108.00	218,087,700.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	51,108.00	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	218,087,700.00
35	БАРАА МАТЕРИАЛ	75,053,683.92	110,072,023.24
351	Түүхий эд материал	35,460,019.70	73,797,553.17
35110	Тусгай зориулалттай материал	12,774,847.25	18,446,765.82
35130	Эм боох материал	22,685,172.45	55,350,787.35
354	Хангамжийн материал	38,033,664.22	35,034,470.07
35410	Бичиг хэргийн материал	1,147,900.00	1,050,700.00
35420	Аж ахуйн материал	14,777,811.22	10,877,248.07
35440	Түлш, шатах тослох материал	4,530,040.00	6,112,920.00
35450	Барилгын засварын материал	2,718,200.00	1,862,200.00
35460	Хүнсний материал	1,882,913.00	2,712,652.00
35470	Бусад хангамжийн материал	12,976,800.00	12,418,750.00
35600	Мал амьтад	1,560,000.00	1,240,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>768,774,459.33</u>	<u>842,201,178.14</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	768,774,459.33	842,201,178.14
392	Биет хөрөнгө	756,144,459.33	829,571,178.14
39201	Барилга, байгууламж, орон сууц	705,180,943.00	714,905,443.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(44,302,045.34)	(74,560,962.50)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,980,000.00	40,980,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(6,764,722.23)	(13,081,388.91)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	116,087,538.80	208,581,374.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	(67,856,417.36)	(59,594,856.97)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,683,410.00	19,633,740.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,864,247.54)	(7,292,170.64)
393	Биет бус хөрөнгө	12,630,000.00	12,630,000.00
39301	Програм хангамж	659,275.00	659,275.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(659,275.00)	(659,275.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	12,630,000.00	12,630,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>843,879,251.25</u>	<u>1,172,883,065.78</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>843,879,251.25</u>	<u>1,172,883,065.78</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	843,879,251.25	1,172,883,065.78
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	180,920,980.80	180,920,980.80
51101	Өмч: - төрийн	180,920,980.80	180,920,980.80

512	Хуримтлагдсан үр дүн	453,472,899.59	782,476,714.12
51210	Өмнөх үеийн үр дүн	453,472,899.59	453,472,899.59
51220	Тайлант үеийн үр дүн	-	329,003,814.53
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	209,485,370.86	209,485,370.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>843,879,251.25</u>	<u>1,172,883,065.78</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	567,327,889.90	1,324,817,188.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	164,782,119.90	367,842,578.38
120	Нийтлэг татварын бус орлого	164,782,119.90	367,842,578.38
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	164,782,119.90	367,842,578.38
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	25,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	164,782,119.90	367,817,578.38
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	402,545,770.00	956,974,610.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	341,905,100.00	389,914,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	341,905,100.00	389,914,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,453,700.00	514,792,740.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,453,700.00	31,403,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,279,140.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого		482,110,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	23,044,800.00	32,680,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23,044,800.00	32,680,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	32,142,170.00	19,586,370.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	32,142,170.00	19,586,370.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	446,255,797.41	995,603,373.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	446,255,797.41	995,603,373.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	441,030,445.70	957,699,837.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	257,753,105.29	362,704,627.00
210101	Үндсэн цалин	220,946,146.73	234,047,785.00
210102	Нэмэгдэл	21,919,625.86	90,400,588.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	632,000.00	3,957,000.00
210104	Урамшуулал	14,255,332.70	34,299,254.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,442,207.00	46,486,511.00
210201	Тэтгэврийн даатгал	21,411,517.00	31,423,447.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,520,983.00	5,387,260.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,006,391.00	2,927,132.00
210204	Ажилгүйдлийн даатгал	405,590.00	605,307.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,097,726.00	6,143,365.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,027,602.00	25,668,910.43
210301	Гэрэл, цахилгаан	2,123,202.00	3,191,910.43
210302	Түлш, халаалт	15,245,000.00	22,477,000.00
210303	Цэвэр, бохир ус	659,400.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	17,954,921.50	36,509,268.65
210401	Бичиг хэрэг	2,323,250.00	1,949,150.00

210402	Тээвэр, шатахуун	8,259,620.00	17,501,260.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	518,900.00	1,021,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	397,650.00	1,854,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,772,500.00	8,005,920.00
210408	Бараа материал акталсны зардал	1,683,001.50	6,177,038.65
2105	Нормативт зардал	46,410,132.45	403,934,523.65
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,069,799.45	386,673,512.65
210502	Хоол, хүнс	6,340,333.00	17,261,011.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,264,600.00	11,355,754.00
210604	Урсгал засвар	5,264,600.00	11,355,754.00
2107	Томилолт, зочны зардал	778,000.00	688,000.00
210702	Дотоод албан томилолт	778,000.00	688,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,609,010.00	5,875,296.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,849,210.00	4,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	285,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	58,000.00	60,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	172,000.00	604,046.00
210807	Газрын төлбөр	126,300.00	126,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	799,950.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,790,867.46	64,476,946.31
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,294,450.00	4,508,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,496,417.46	59,968,146.31
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,225,351.71	37,903,536.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	33,457,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	4,257,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	29,200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	746,638.00	4,446,136.57
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	746,638.00	4,446,136.57
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,478,713.71	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,478,713.71	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	121,072,092.49	329,213,814.77
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	210,000.24
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	0.24
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	210,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(210,000.24)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	121,072,092.49	329,003,814.53

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	180,920,980.80	209,485,370.86	332,400,807.10	722,807,158.76
C02	Нягтлан бодох бүртгэлийн	0.00	0.00	0.00	0.00

	бодлогын өөрчлөлт				
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	180,920,980.80	209,485,370.86	332,400,807.10	722,807,158.76
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	121,072,092.49	121,072,092.49
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	180,920,980.80	209,485,370.86	453,472,899.59	843,879,251.25
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	180,920,980.80	209,485,370.86	453,472,899.59	843,879,251.25
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	180,920,980.80	209,485,370.86	453,472,899.59	843,879,251.25
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	329,003,814.53	329,003,814.53
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	180,920,980.80	209,485,370.86	782,476,714.12	1,172,883,065.78

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	402,545,770.00	738,911,910.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	25,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	25,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	25,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	25,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	402,545,770.00	738,886,910.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	341,905,100.00	389,914,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	341,905,100.00	389,914,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,453,700.00	296,705,040.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,453,700.00	31,403,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,279,140.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого		264,022,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	23,044,800.00	32,680,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23,044,800.00	32,680,700.00

1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	32,142,170.00	19,586,370.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	32,142,170.00	19,586,370.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	390,634,270.00	736,389,745.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	390,634,270.00	736,389,745.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	385,408,918.29	698,486,209.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	257,753,105.29	362,704,629.00
210101	Үндсэн цалин	220,946,146.73	234,047,787.00
210102	Нэмэгдэл	21,919,625.86	90,400,588.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	632,000.00	3,957,000.00
210104	Урамшуулал	14,255,332.70	34,299,254.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,493,315.00	46,435,401.00
210201	Тэтгэврийн даатгал	21,446,271.00	31,372,337.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,525,071.00	5,387,260.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,009,662.00	2,927,132.00
210204	Ажилгүйдлийн даатгал	406,408.00	605,307.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,105,903.00	6,143,365.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,027,602.00	25,929,910.43
210301	Гэрэл, цахилгаан	2,123,202.00	3,191,910.43
210302	Түлш, халаалт	15,245,000.00	22,477,000.00
210303	Цэвэр, бохир ус	659,400.00	261,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,878,550.00	41,384,750.00
210401	Бичиг хэрэг	2,505,750.00	1,871,950.00
210402	Тээвэр, шатахуун	10,701,700.00	18,425,380.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	518,900.00	1,021,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,003,050.00	1,854,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,149,150.00	18,211,520.00
2105	Нормативт зардал	30,697,236.00	197,898,368.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,174,286.00	178,900,768.60
210502	Хоол, хүнс	7,514,950.00	16,991,350.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,008,000.00	2,006,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,101,450.00	10,499,754.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	200,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,209,750.00	-
210604	Урсгал засвар	4,691,700.00	10,499,754.00
2107	Томилолт, зочны зардал	778,000.00	688,000.00
210702	Дотоод албан томилолт	778,000.00	688,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,609,010.00	5,875,296.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,849,210.00	4,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	285,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	58,000.00	60,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	172,000.00	604,046.00
210807	Газрын төлбөр	126,300.00	126,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	799,950.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,070,650.00	7,070,100.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,070,650.00	7,070,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,225,351.71	37,903,536.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	33,457,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	4,257,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	29,200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	746,638.00	4,446,136.57
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	746,638.00	4,446,136.57
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,478,713.71	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,478,713.71	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	11,911,500.00	2,522,164.40
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,911,500.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,911,500.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	11,911,500.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,911,500.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(11,911,500.00)	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	2,522,164.40
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,522,164.40

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	453,894,000.00	437,275,890.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	453,894,000.00	437,275,890.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	449,619,000.00	433,018,490.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	310,075,300.00	299,921,154.00
210101	Үндсэн цалин	186,003,700.00	177,934,279.00
210102	Нэмэгдэл	90,400,900.00	90,400,588.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,819,000.00	3,957,000.00
210104	Урамшуулал	27,851,700.00	27,629,287.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,429,900.00	40,812,697.00
210201	Тэтгэврийн даатгал	29,867,200.00	28,932,886.00

210202	Тэтгэмжийн даатгал	3,140,500.00	3,116,470.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,476,600.00	2,442,396.00
210204	Ажилгүйдлийн даатгал	628,100.00	562,760.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,317,500.00	5,758,185.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,180,700.00	25,734,563.43
210301	Гэрэл, цахилгаан	4,090,100.00	2,996,563.43
210302	Түлш, халаалт	25,823,000.00	22,477,000.00
210303	Цэвэр, бохир ус	267,600.00	261,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,649,500.00	23,642,430.00
210401	Бичиг хэрэг	1,012,000.00	1,011,950.00
210402	Тээвэр, шатахуун	17,760,000.00	17,757,780.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,023,300.00	1,021,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,854,200.00	1,854,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	1,996,800.00
2105	Нормативт зардал	26,777,000.00	26,774,250.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,805,000.00	17,805,000.00
210502	Хоол, хүнс	6,963,000.00	6,963,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,009,000.00	2,006,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,500,000.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	2,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	788,000.00	688,000.00
210702	Дотоод албан томилолт	788,000.00	688,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,147,400.00	5,875,296.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,000,000.00	4,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	285,400.00	285,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	60,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	853,700.00	604,046.00
210807	Газрын төлбөр	126,300.00	126,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	800,000.00	799,950.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,071,200.00	7,070,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,071,200.00	7,070,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,275,000.00	4,257,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,275,000.00	4,257,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,275,000.00	4,257,400.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	63,979,200.00	47,820,933.43
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	32,680,700.00	28,234,563.43
122005	Орон нутгийн төсвөөс	32,680,700.00	28,234,563.43
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	31,298,500.00	19,586,370.00
122001	Хандив тусламж /дотоод/	31,298,500.00	19,586,370.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	484,843.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	-	-
620001	Удирдах ажилтан		
620002	Гүйцэтгэх ажилтан		
620003	Үйлчлэх ажилтан		
620004	Гэрээт ажилтан		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	294,667,718.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	294,667,718.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	265,467,718.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	62,783,475.00
210101	Үндсэн цалин	56,113,508.00
210104	Урамшуулал	6,669,967.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,622,704.00
210201	Тэтгэврийн даатгал	2,439,451.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,270,790.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	484,736.00
210204	Ажилгүйдлийн даатгал	42,547.00
210205	Эрүүл мэндийн даатгал	385,180.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	195,347.00
210301	Гэрэл, цахилгаан	195,347.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,742,320.00
210401	Бичиг хэрэг	860,000.00
210402	Тээвэр, шатахуун	667,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,214,720.00
2105	Нормативт зардал	171,124,118.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	161,095,768.60
210502	Хоол, хүнс	10,028,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,999,754.00
210604	Урсгал засвар	7,999,754.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,200,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	296,705,040.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	296,705,040.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	296,705,040.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,403,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,279,140.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	264,022,300.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	2,037,321.40
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,037,321.40

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Должинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, газрын дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 02/13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дундговь аймгийн Адаацаг сумын Эрүүл мэндийн төв нь эрхэм зорилгоо “Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог сайжруулж, өвчнийг эрт илрүүлэх, хариу арга хэмжээг чанартай хүртээмжтэй зохион байгуулах, эрт илрүүлгийн тогтолцоо, лабораторийг бэхжүүлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй зохион байгуулж дундаж наслалтыг 71-д хүргэх” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 оны 09 сар хүртэлх баримт материалд аудит хийж, ажил сайжруулах 5 зөвлөмж өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 4 дүгээр улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 4 дүгээр улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг 908,741.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 9,087.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,361.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд аймгийн ЭМГ-тай тооцоо нийлээгүйн улмаас эм боох материалтай холбоотой залруулга хийгдэж, санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 995,603.3 мянган төгрөг болсон.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 995,603.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 9,956.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,969.2 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дундговь аймгийн Дундговь аймгийн Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 329,003.8 мянган төгрөгөөр буюу 38.9 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан хөрөнгийн данс нь эргэлтийн хөрөнгийн данс бөгөөд 218,036.6 мянган төгрөгийн дансны авлага өссөн нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Эргэлтийн хөрөнгийн дүн	75,104.8	330,681.9	255,577.1
Мөнгөн хөрөнгө	-	2,522.2	2,522.2
Авлага	51.1	218,087.7	218,036.6
Бараа материал	75,053.7	110,072.0	35,018.3
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	768,774.5	842,201.2	73,426.7
Үндсэн хөрөнгө	768,774.5	842,201.2	73,426.7
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	843,879.3	1,172,883.1	329,003.8
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	843,879.3	1,172,883.1	329,003.8
Засгийн газрын хувь оролцоо	843,879.3	1,172,883.1	329,003.8
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	843,879.3	1,172,883.1	329,003.8

Бараа материал дансны үлдэгдэл 110,072.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 35,018.3 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материалын дансны өсөлт байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 9,724.5 мянган төгрөгөөр эмнэлгийн барилгад засвар хийж, 106,144.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,200.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг хандиваар авсан байна. Мөн 16,326.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг эд хариуцагчид хуваарилан, 32,226.2 мянган төгрөгийн эд хөрөнгийг акталж, устгасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,172,883.1 мянган төгрөг болж 329,003.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 398,960.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 398,960.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 54,933.9 мянган төгрөгөөр өсгөн 453,894.0 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн өсөлт нь цар тахлын үеийн бэлэн байдлын зардлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 453,894.0 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Батлагдсан төлөвлөгөөнөөс хандив тусламжийн орлого 11,687.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 4,446.1 мянган төгрөгийн санхүүжилт дутуу орсон байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 437,760.7 мянган төгрөгийн санхүүжилт авсан нь урсгал үйл ажиллагаанд нийт төсвийн 99.8 хувийг зарцуулж, үндсэн санхүүжилтийн дансанд 484.8 мянган төгрөг үлдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 437,275.9 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь цалин хөлс болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын гүйцэтгэл буюу батлагдсан орон тооноос дутуу үйл ажиллагаагаа явуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд ЭМД-ын сангаас 264,022.3 мянган төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 31,403.6 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 1,279.1 мянган төгрөг, нийт 296,705.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс үйл ажиллагааны зардалд 294,667.7 мянган төгрөгийг зарцуулж, 2,037.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Коронавируст халдварын цар тахалтай тэмцэх арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн яамнаас нийт 201,765.4 мянган төгрөгийн эм, эмийн хэрэгслүүдийг аймгийн ЭМГ-аар дамжуулан хуваарилсан байна.

Хуваарилсан эмийн 24,302.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, вакцины орлогыг аваагүй, зарлагыг тусгаагүй байсныг аудитын явцад залруулсан.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй тул гол асуудал байхгүй гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Адаацаг сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 750,236.9 мянган төгрөгийн 165 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулахаас 14 мэдээллийг хугацаа хоцроож, хэрэгжилт 91.5 хувьтай байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 төлбөрийн акт, 3 албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд завсрын аудитаар хяналтын тооллого хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,741.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 606.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3,135.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар нийт 606.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Ковидын шинжилгээний төлбөр 606.0 төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

4.3 Албан шаардлага

Аудитаар нийт 3,135.3 мянган төгрөгийн зөрчилд хугацаатай албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Орон тоо, цалингийн сан батлагдаагүй ажлыг хавсруулан гүйцэтгүүлж, ажил хавсарсны нэмэгдэлд 3,135.3 мянган төгрөгийн цалин бодож олгосон.

Шийдвэрлэсэн нь: Хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн агуулга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:											
	Дүн										
2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	Ковидын шинжилгээний төлбөр 606.0 төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн	1	606.0			1	606.0				
2	Орон тоо, цалингийн сан батлагдаагүй ажлыг хавсруулан гүйцэтгүүлж, ажил хавсарсны нэмэгдэлд 3,135.3 мянган төгрөгийн цалин бодож олгосон	1	3,135.3					1	3,135.3		
	Дүн	2	3,741.3			1	606.0	1	3,135.3	0	0
	Нийт дүн	2	3,741.3			1	606.0	1	3,135.3	0	0